



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/109

Арвайхээр

**Буцалтгүй тусламж олгох тухай**

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын 2018 оны А/676 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам”-ын 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргад хандаж мөнгөн тусламж хүсч өргөдөл ирүүлсэн Арвайхээр сумын 8 дугаар багийн иргэн У.Алтанцэцэгийн нөхөр нь зуурдаар нас барж, 3 хүүхэдтэй өрх толгойлж үлдсэн тул амьжиргааны баталгаажих түвшин доогуур орлоготойг харгалзан үзэж 1000000 (нэг сая) төгрөгний нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгосугай.

2. Дээрх иргэнд олгох 1000000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100239